


## Сиси системийг ашиглан Microsoft Office 365 үйлчилгээнд нэвтрэх нууц үг сэргээх заавар

- Сиси системд өөрийн эрхээр нэвтрэнэ. /Хэрэв та Сиси системд нэвтрэх эрхгүй бол Бичиг хэрэг, Хүний нөөцийн ажилтнаас авна уу./



- Зүүн гар талд байрлах “Цахим шуудан” цэсрүү орно уу. Энд таны бүртгэлтэй цахим шуудангийн хаягууд байна. Эндээс МУИС-д хамаарах цахим шуудангийн хаягийнхаа нууц үгийг солих боломжтой бөгөөд харгалзах хаягны хойно байрлах “Нууц үг сэргээх” гэсэн товчийг дарж шинэ нууц үгээ оруулна.

**Анхаар:** Солигдсон тухай мэдээлэл гарч ирснээс хойш хэсэг хугацааны дараа таны нууц үг солигдохыг анхаарч хүлээнтэй хандана уу.

Бүртгэлтэй цахим шуудангийн хаягууд	
<b>Цахим шуудангийн хаягууд</b>	
oyunomin@num.edu.mn	Нууц үг сэргээх
nomio@num.edu.mn	Нууц үг сэргээх
b.oyunomin@gmail.com	

3. Хэрэв таны цахим шуудангийн хаяг бүртгэгдээгүй байгаа бол “Цахим шуудангийн хаяг бүртгүүлэх” гэсэн товчийг дарна уу. Энд та өөрийн ашиглаж буй ямар ч цахим шуудангийн хаягийг Сиси систем дэх өөрийн мэдээлэлдээ нэмж бүртгүүлэх, МУИС-д харьяалагдах хаягийнхаа нууц үгийг солих боломжтой болно.

**Анхаар:** Бүртгүүлсэн хаягаар тань баталгаажуулах шуудан очих тул та тус хаягуугаа нэвтэрч чаддаг байх ёстойг анхаарна уу.

#### Цахим шуудангийн хаяг бүртгүүлэх

Энд та өөрт холбогдох дурын цахим шуудангийн хаягаа бүртгүүлэх боломжтой. Таны бүртгүүлсэн цахим шуудангийн хаягаар баталгаажуулах шуудан илгээнэ.

4. Бүртгүүлэх хаягаа бичээд “Илгээх” товчийг дарснаар тус хаягуу “Баталгаажуулах” шуудан илгээгднэ. Та шуудангаа шалгаж “Баталгаажуулах” товчийг дарснаар таны хаягийг бүртгэж авах болно.

**Анхаар:** Таны илгээсэн хүсэлт 24 цагийн хүчинтэй бөгөөд баталгаажуулаагүй 24 цаг өнгөрсөн тохиолдолд та дахин хүсэлт илгээх шаардлагатайг анхаарна уу.



#### И-МЕЙЛ ХАЯГ НЭМЭХ ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛНА УУ.

Сайн байна уу. Та SISi системд [b.oyunomin@gmail.com](mailto:b.oyunomin@gmail.com) гэсэн хаягийг өөрт холбогдох хаягаар нэмэх хүсэлт гаргасан байна. "Батлах" сонгосноор таны и-мейл хаягийг эцсийн байдлаар бүртгэж авах болно. Хэдий энэ хүсэлт нь 24 цаг хүчинтэй ч дахин системээр орж хүсэлт гаргах боломж таньд нээлттэй байгааг санаарай.

[Баталгаажуулах](#)

- Хэрэв та өмнө нь МУИС-ийн цахим шуудангийн хаягийг ашиглаж байсан боловч нууц үгээ мартсан, ашиглахгүй удсан бол “**Цахим шуудангийн хаяг сэргээх**” гэсэн товчийг дарна уу. Энд дарж хаягаа сэргээх хүсэлт илгээнээр бид таны хүсэлтийг хүлээн авч, холбогдох мэдээллүүдийг шалган, хаягийг баталгаажуулах ба мэдээлэл зөрсөн тохиолдолд хүсэлтийг буцаах болно. Баталгаажуулсны дараа та шинэ нууц үг хийх боломжтой болно.  
**Анхаар:** Таны мэдээллийг шалгаж хаягийг баталгаажуулах, сэргээхэд тодорхой хугацаа шаардагдахыг анхаарна уу.

#### Цахим шуудангийн хаяг сэргээх

Та энд дарж өмнө нь ашиглаж байсан МУИС-ийн цахим шуудангийн хаягаа сэргээх хүсэлт илгээнэ үү.

- Танд энэхүү системтэй ажиллахад ямар нэгэн ойлгомжгүй, тодорхойгүй зүйл гарвал 1154 дотуур утасруу залгаж Мэдээллийн Технологийн Албанад хандана уу.